

НАСРЕТТИН ХОЖА

ИЛЖТЭЭ
ЗЭЭЛДҮҮЛЭЭЧ



Насреттин хожагийн
онигооны түүвэр - 1

ТОНУРГУК
YAYINLARI



Илжгээ зээлдүүлээч

Эрхлэн гаргасан: Эмпати-Ертөнц ХХК

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Цэцэг ногоо дэлгэрсэн хаврын сайхан өдөр байжээ. Насреттин Хожа

өвлийн хүйтэнд хугарч, хагарсан дээврээ засахаар гэрийнхээ дээвэр дээр гарч гэнэ.

Яг тэр үед тэдний гэрийн хаалгыг хэн нэгэн тогшив. Насреттин Хожа хийж байсан ажлаа орхиод доошоо тонгойж харжээ. Холоос харахад таньдаг хүн шиг байсан ч, яг хэн болохыг нь санасангүй гэнэ. Тэр хүний нүд нь гархилсан, нүүр нь үрчийсэн, хөл гар нь чичирч, маш өрөвдөлтэй харагджээ.

Хөгшин эр :

- Насреттин Хожа, Насреттин Хожа гэж дуудав.



Насреттин Хожа:

- Яасан бэ? Та ямар хэргээр явж байна даа? гэж асуухад

Хөгшин эр:

- Өршөөгөөрэй Насреттин Хожа минь, та доошоо бугаад ирэхгүй юу? гэлээ.

Насреттин Хожагийн уур нь хүрч, хүн завгүй байхад гэж ундууцан:

- Хэлэх гэж байгаа үгээ наанаасаа хэлчих, би энд их ажилтай байна шүү дээ гэлээ.

Харин тэднийд ирсэн хүн түүнийг доош нь дуудсан хэвээр л байжээ.



Насреттин Хожа ингээд бүтэхгүй юм байна гэдгийг ойлгоод арайхийн гарсан дээвэр дээрээсээ бас арай гэж буужээ. Хожа түүний дэргэд ирээд, түүнийг өрөвдөх нь битгий хэл, ажилд нь садаа болсон тул сайн сургахаар иртэл, тэр хүн огт танихгүй хүн байж гэнэ.

Хөгшин эр:

- Бурханы нэрээр надад хэдэн төгрөг хайрлаач гэжээ.

Насреттин Хожа хөгшин эрийг дээрээс доош ажин хараад “Хн” гэж үглэн, түүнийг сугадаад

- За намайг дагаад яв гэлээ.

Шат өөд хамтдаа өгсөн, дөчин нэгдүгээр гишгүүр дээр ирээд огт санаа зовсон шинжгүй хөгшин эр рүү эргэн хараад :

- За хүн гуай, Бурханаас өөрөөс нь гуй даа гэсэн гэдэг.



Н^омр^ог дотор би ÷ бас байсан шүү дээ

Нэг өглөө Насреттин Хожа уурлан гадагшаа гарчээ. Түүний хөрш нь Хожаг уурлан гарч явахыг хараад тэсэлгүй цонхоо тогшжээ. Насреттин Хожа цонх тогшихыг сонсоод хартал түүний хөрш сонирхсон харцаар түүнийг ширтэн зогсож байв.

Хөрш нь:

- Насреттин Хожа юу болоо вэ? Өнөөдөр та нэг л өөр байх чинь гэжээ.

Насреттин Хожа :

- Зүгээрээ хөрш минь, юу л болов гэж! гэлээ.



Ингэж хэлээд цааш явах гэтэл түүний хөрш гарч ирээд,

- Битгий ингэ л дээ. Та нэг л сонин харагдаад байх чинь, ямар нэгэн юм болсон юм шиг л байна даа гээд урдуур нь ээрэв.

Насреттин Хожа хөрш рүүгээ хараад бодлогошрон, өөрөөр нь тоглож байгааг ойлгов.

- Хөрш минь, хөрш минь! Чамд ер нь хүний уур хилэн ямар хамаатай юм бэ ! Айл болгонд ийм зүйл гардаг л биз дээ. Би эхнэртэйгээ жаахан маргалдсан юм гэлээ.



Ингэж хэлээд цааш явах гэтэл хөрш нь бүр их сүр бадруулж:

- Тийм байлгүй дээ, өчигдөр орой танайх нэлээн дуу шуугиантай байх шиг байсан шүү. Надаас юуг нь нуух гэсэн юм бэ! гэв.

Ер нь хөршөөсөө салах аргагүй гэдгээ ойлгосон Насреттин Хожа “Тийм бий вий!” гэж дотроо үглээд, цээж мөрөө тэгшлэн цэх зогслоо. Хөрш нь түүнийг ажиглан зогсоод, юу хэлэх бол гэж хүлээнэ.



Насреттин Хожа:

- Хэлээд юу гэх вэ хөрш минь, уг нь тийм их сонирхоод байх зүйл байхгүй л дээ. Харин чи ингээд шалгаагаад байх юм. Хэлэхээс биш дээ. Манай эхнэр уурлаад, миний нөмрөгийг өшиглөчихсөн. Гэтэл нөмрөг маань шатнаас доошоо өнхөрч унаад баларсан юм болсон гэв.

Хөрш нь инээдээ барьж чадалгүй инээж:

- Хожа минь ээ, яаж тийм юм байж болох вэ? Нөмрөг унахад тийм их чимээ юу гэж гарахав дээ гэлээ.

Насреттин Хожа:

- Хөрш минь, чи яасан ядаргаатай юм бэ! Үүнд чинь ойлгож ядаад байх юу байсан юм бэ? Нөмрөг дотор би ч гэсэн байсан юм гэжээ.



Илжгээ зээлдүүлээч


Насреттин Хожа гэртээ тухлан суугаад өглөөнийхөө цайг ууж байжээ. Гэтэл хөрш нь үүдийг нь тогшжээ. Эхнэр нь хаалганд ойрхон байсан болохоор хаалгаа нээв.

Хөрш нь:

- Насреттин Хожа гэртээ байна уу? гэж асуув. Эхнэр нь:

- Байна гэжээ. Нөхрийгөө дуудаад:

- Чамайг хүн асууж байна гэлээ.



Насреттин Хожа үүдэндээ ирээд:

- Юу болсон бэ? гэж асуув. Хөрш нь:

- Уучлаарай! Та надад илжгээ зээлдүүлээч гэжээ.

Насреттин Хожа нэг л өгмөөргүй санагдаад, түүнийг хоосон буцаахаар шийджээ. Харин ямар шалтаг тоочихоо мэдэхгүй:

- Манай илжиг сүүлийн үед их ажиллаж байгаа болохоор их ядарсан байгаа. Гэхдээ яахав очоод нэг үзэцгээ. Манай илжиг бас юу гэхнэв, сонсох хэрэгтэй гэлээ.



Хөрш нь үүнийг сонсоод маш их гайхсан боловч Насреттин Хожагийн үүдэнд хүлээсэн хэвээр л байлаа.

Насреттин Хожа илжигнийхээ дэргэд очоод, буцаад ирэв. Хөрш нь:

Яасан бэ? гэхэд

Насреттин Хожа :

Одоо яадаг билээ! Манай илжиг надад нэг арга зааж өглөө, харин чамд хэлдэг юм билүү, яадаг юм билээ гэжээ.



Хөрш нь үүнийг сонсоод дургүйцэв. Насреттин Хожагийн энэ тохуурхсан байдлыг ойлгож чадахгүй байлаа.

- За боль доо та. Илжиг яаж хүнд арга зааж өгдөг юм бэ? гэхэд

Насреттин Хожа :

Манай илжиг надад хэлэхдээ: “Би ямар ч замд явж юу ч байсан хийж чадна. Харин хүний хүн надад яаж хандахыг мэдэхгүй байна. Юмыг яаж мэдэхэв, би илжиг болсон хойно болох бүтэхгүй юм хийчихвэл хөрш ирээд чамтай л тооцоо хийнэ шүү дээ” гэсэн юм гэжээ.



Бороо орвол ...

Нэгэн орой Насреттин Хожа гэртээ ирээд эхнэртэйгээ ярилцаж суужээ. Ойр зуурын юм ярьж суугаад:

Насреттин Хожа:

- Би маргааш тэнгэр сайхан бол талбайд очно гэж бодож байна. Харин бороо орвол уул руу явж мод бэлтгэе гэлээ.

Эхнэр нь Насреттин Хожаг гайхсан байртай хараад:

- Тэг дээ. Гэхдээ юмыг яаж мэдэх вэ! гэжээ.

Насреттин Хожа үүнийг сонсоод уурлан:

- Үүнд чинь эргэлзээд байх юу байсан юм бэ? Тэнгэрийн байдлыг ажаад ийшээ эсвэл тийшээ гэв.



Эхнэр нь мөн л :

- Юмыг яаж мэдэхэв өвгөн минь гэлээ.

Унтаж амраад маргааш өглөө нь тэнгэрийн байдлыг хартал бороо орох шинжтэй байжээ. Уул руу мод бэлтгэхээр явахаас өөр сонголт байсангүй.

Насреттин Хожа явсаар явсаар ойд иржээ. Гэтэл түүний зам дээр дээрэмчид зогсож байлаа. Насреттин Хожа мэддэг бүх тарниа уншиж, тэднээс намайг явуулчихаач дээ гэж мөн ч их гуйжээ. Тэд түүний гуйлтыг зөвшөөрсөнгүй.

Дээрэмчдийн толгойлогч :

Насреттин Хожа, чи ч их айхгар хүн шиг байна. Бидэнд чи л хэрэгтэй байна яг одоо. Бидэнд тосгон орох замыг зааж өг гэлээ.



Насреттин Хожа :


- Би их ажилтай байна, та нар өөр хүн олчих гэлээ. Дээрэмчдийн толгойлогч :

Тэр чинь надад ямар хамаатай юм бэ! Илүү дутуу юм битгий яриад бай, урд гараад яв гэжээ.

Насреттин Хожа байдал эвгүйтсэнийг анзаарч, тэдний аясыг дагасан нь өөрт нь өлзийтэйг ойлгон:

- За гэлээ.

Насреттин Хожа дээрэмчдэд зам заан явсаар, явсаар байлаа. Дээрэмчид ч маш их ядарсан байв. Бараг л хөл дээрээ зогсох тэнхэлгүй болжээ.



Маш их ядарсан байсан болохоор ч тэр үү, тосгонд ирээд Насреттин

Хожаг зүгээр явуулчихжээ.

Насреттин Хожа тэднээс салаад эргэж ч харалгүй гэрийн зүг гүйсээр явав. Өөрт нь ийм зүйл тохиолдсонд итгэж чадахгүй байлаа. Эцэст нь гэрийнхээ үүдэнд ирээд, дахин уул руу явж мод хийхгүй хэмээн өөртөө амлажээ. Хаалгаа нэлээд ширүүн тогшив.

Эхнэр нь :

- Хэн бэ? Хожаг асууж байгаа бол гэртээ байхгүй байна гэжээ. Насреттин Хожа :

- Дэмий юм битгий яриад бай эхнэр минь, хаалгаа түргэн онгойлго.

Би ирчих шиг боллоо гэсэн гэдэг.



Table of Contents

[Бороо орвол ...](#)